



**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2026 оны 01 сарын 23 өдөр

Дугаар 8/К

Улаанбаатар хот

Комисс байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Хаягжуулалтын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.5 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 325 дугаар тогтоол, 2022 оны 180 дугаар тогтоолыг үндэслэн тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дүүргийн гудамж, зам талбайд нэр өгөх, өөрчлөх, нэрэмжит болгох санал боловсруулах орон тооны бус комиссын бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.


2. Гудамж талбайд нэр өгөх, өөрчлөх, нэрэмжит болгох саналыг газар зүйн нэрийн болон хаягийн мэдээллийн сангийн мэдээлэлтэй тулган хянаж, саналыг боловсруулан, үр дүнг тооцож дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлж, тайлагнаж ажиллахыг Орон тооны бус комисс (Х.Цогцэцэг)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

Багахангай дүүргийн Засаг даргын
2026 оны ... сарын ...-ны өдрийн
... дугаар захирамжийн хавсралт



Ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Дарга:	Засаг даргын орлогч
Гишүүд:	Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын албаны Зохион байгуулалтын хэлтсийн дарга(зөвшилцсөнөөр)
	Дүүргийн менежер
	Засаг даргын тамгын газрын дарга
	Хотын стандарт, тохижилт нийтийн аж ахуйн хэлтсийн дарга
	Онцгой байдлын хэлтсийн дарга
	Улсын бүртгэлийн хэлтсийн дарга
	1 дүгээр хорооны Засаг дарга
	2 дугаар хорооны Засаг дарга
	Статистикийн мэргэжилтэн
Нарийн бичгийн дарга:	Газар зохион байгуулалтын албаны дарга